



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 04 сарын 15 өдөр

Дугаар А/99

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой байдлын байгууллагын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах журам”-ыг нэгдүгээр, зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэхийг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлагаар ханган ажиллахыг Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга (хурандаа Б.Мандахгэрэл)-т, Гал түймэртэй тэмцэх газрын дарга (хурандаа Ц.Нямбаяр)-т нарт даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга (бригадын генерал Т.Ариунбуян)-д үүрэг болгосугай.


ДАРГА,  
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Т.БАДРАЛ

00000938

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн  
А/99.. дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



## ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл (цаашид “зөвлөл” гэх)-ийн үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

1.2 Зөвлөлийн зорилго нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль болон Олон улсын хөдөлмөрийн байгууллагын дүрэм, журам, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн хүрээнд Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах, ажлын байрны нөхцөлийг сайжруулж, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрүүл ахуйн зохистой орчныг бүрдүүлэхэд оршино.

1.3 Зөвлөл нь хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах хараат бус байх зарчмыг баримтална.

### Хоёр. Зөвлөлийн үйл ажиллагааны зохион байгуулалт

2.1 Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй байна. Зөвлөл нь 5-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.2 Онцгой байдлын байгууллагын харьяа нэгж нь салбар зөвлөлтэй байх ба (Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбар) 3-5 хүний бүрэлдэхүүнтэй байж болно.

2.3 Зөвлөлийн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байх ба нийт гишүүдийн 60-аас дээш хувийн ирцтэй зохион байгуулна.

### Гурав. Зөвлөлийн эрх, үүрэг

3.1 Зөвлөл / салбар зөвлөл / нь Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/114 дүгээр тушаалын хавсралтын 3 дугаар зүйлд заасан чиглэлээс гадна дараах чиглэлээр эрх, үүргийг хэрэгжүүлнэ


3.2 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл нь байгууллагын түвшинд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, хяналт тавина.

3.3 Зөвлөл нь ажлын төлөвлөгөө боловсруулж тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, алба хаагчийн эрүүл мэнд, нийгмийн баталгааг хангуулах талаар санал, санаачлага гаргаж ажиллана.

3.4 Хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежмент, шинэ техник технологи, инновацийг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.

3.5 Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогоос урьдчилан сэргийлэх талаар мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллана.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын  
2020 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн  
А/99.. дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,  
ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛ, САЛБАР ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. Зөвлөлийн бүрэлдэхүүн:

Зөвлөлийн дарга:

- Төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын дарга, захирагч

Гишүүд:

- Газрын орлогч дарга;
- Хэлтсийн дарга;
- Улсын нөөцийн салбарын дарга;
- Гал түймэр унтраах, аврах ангийн захирагч;
- Аврах ангийн захирагч;
- Эрэн хайх, аврах салбарын дарга, захирагч;
- Салааны захирагч;
- Бүлгийн дарга;
- Нягтлан, нярав;
- Амьсгалын бие даасан төхөөрөмжийн засварчин- гал сөнөөгч;

Нарийн бичиг;

- Техник, тоног төхөөрөмж, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн.
- Эмч, сэтгэл зүйч

2. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн:

Дарга:

- Хэлтэс, анги, салбарын дарга, захирагч;

Гишүүд:

- Салааны захирагч;
- Бүлгийн дарга;
- Нярав;
- Амьсгалын бие даасан төхөөрөмж хариуцсан албан тушаалтан;
- Шуурхай удирдлагын оператор;
- Ахлах жолооч, жолооч.

Нарийн бичиг:

- Салааны захирагчийн туслах, бага дарга;
- Нөөцийн салбарын нягтлан, нярав

Тайлбар: Улсын нөөцийн анги, салбаруудад дээрх албан тушаалтны нэгэн адил томилогдоно.

3.6. Хамгаалах тусгай хувцас, хамгаалах хүн нэг бүрийн хэрэгслийн хангалт, хэрэглээ, ажлын байр, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангуулна.

3.7. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн талаар алба хаагч, ажилтны гаргасан санал, хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэнэ.

3.8. Зөвлөл нь улиралд нэгээс доошгүй удаа хуралдаж үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилийн гүйцэтгэлээр гарган Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газарт ирүүлнэ.

3.9. Хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн үйлдлийг таслан зогсоох, буруутай этгээдэд хариуцлага тооцох талаар санал боловсруулж захирагч, даргад уламжлана.

3.10. Хариуцсан ажилдаа идэвх, санаачилга гарган, үр дүнтэй ажилласан ажилтан, алба хаагчдыг шагнаж, урамшуулах санал гаргаж шийдвэрлүүлнэ.

#### Дөрөв. Хариуцлага

4.1. Зөвлөлийн гишүүний хууль ёсны шаардлагыг үл биелүүлсэн алба хаагчдад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцно.

#### Тав. Бусад

5.1. Журмын хэрэгжилтийн явц болон үр дүнд дотоод хяналт шалгалт аюулгүй байдлын асуудал эрхэлсэн бүтцийн нэгж жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж Онцгой байдлын ерөнхий газрын даргын зөвлөлд танилцуулна.

— оОо —